



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/161

Булган сум


### Гадаад албан томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Булган аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга Ж.Ганболдыг 2024 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнги аймгийн Шинхан их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд албан уулзалт хийхээр ажиллуулсугай.

2.Гадаад томилолт, тийз, бусад зардалд шаардагдах 4,095,680 (дөрвөн сая ерэн таван мянга зургаан зуун наяд) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын “Шинэ багш” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
03 дугаар сарын 14-ны өдрийн А/16 дугаар  
захирамжийн хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ /төгрөг/	Мөнгөн дүн /төгрөг/
1	УБ-Сөүл-УБ тийзний зардал	1 хүн	1,395,000	1,395,000
2	Томилолт	4 хоног	200 доллар	2,700,680
<b>Нийт дүн</b>				<b>4,095,680</b>

Жич:

1 доллар = 3,375.85

/2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн Монгол банкны хаалтын ханш/